

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/237-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аудитор Т.Мөнхзул Утас: 70363036 Цахим хаяг: Munkhzult@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.14 № СЭА-2022/237-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

САЙХАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ
ЗӨВЛӨХ Б.МӨНХДӨЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

СЭА-2022/237-НА-СТА-ТШЗ

018020034


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕП	Монгол Улсын Ерөнхий прокурор
МУЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/ төгрөгөөр /
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,279,825.00	25,552,535.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,000,000.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,000,000.00	0
31210	Төгрөг	20,000,000.00	0
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,000,000.00	0
34	УРЬДЧИЛГАА	0	14,240,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0	14,240,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,279,825.00	11,312,535.00
35100	Түүхий эд материал	2,637,375.00	711,375.00
35110	Тусгай зориулалттай материал	711,375.00	711,375.00
35130	Эм боох материал	1,926,000.00	0
35400	Хангамжийн материал	6,642,450.00	10,601,160.00
35410	Бичиг хэргийн материал	2,655,350.00	2,483,150.00
35420	Аж ахуйн материал	3,309,100.00	3,846,510.00
35450	Барилгын засварын материал	110,500.00	316,000.00
35470	Бусад хангамжийн материал	567,500.00	3,955,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	225,861,873.60	242,357,158.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	225,861,873.60	242,357,158.35
39200	Биет хөрөнгө	217,641,873.60	234,137,158.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,302,259.00	154,302,259.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,089,048.40	-16,260,196.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,243,996.67	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,162,664.48	-11,666,666.64
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	34,799,791.66	63,785,979.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,372,355.18	-19,354,411.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,112,030.43	39,112,030.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,735,105.28	-12,212,975.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,766,629.50	1,766,629.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-223,660.32	-335,490.48
39300	Биет бус хөрөнгө	8,220,000.00	8,220,000.00
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-715,000.00	-715,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,220,000.00	8,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	255,141,698.60	267,909,693.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,000,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,000,000.00	0
41400	Урьдчилж орсон орлого	20,000,000.00	0
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	20,000,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	235,141,698.60	267,909,693.35
51	Засгийн газрын хувь оролцоо	235,141,698.60	267,909,693.35

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,082,380.00	72,082,380.00
51200	Хуримтлагдсан үр дүн	86,793,956.60	119,561,951.35
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,912,262.05	86,793,956.60
51220	Тайлант үеийн үр дүн	88,706,218.65	32,767,994.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,265,362.00	76,265,362.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	255,141,698.60	267,909,693.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	337,138,638.09	395,484,588.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,160,038.09	24,978,188.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,160,038.09	24,978,188.00
120009	Бусад орлого	175,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	47,985,038.09	21,999,188.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	2,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	288,978,600.00	370,506,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	288,978,600.00	370,506,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	288,978,600.00	370,506,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	248,432,419.44	362,175,927.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,432,419.44	362,175,927.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	226,609,033.44	351,296,575.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,161,858.00	220,972,682.00
210101	Үндсэн цалин	159,161,858.00	141,997,039.00
210102	Нэмэгдэл	0	67,105,643.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	11,870,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,846,381.00	27,097,548.00
210201	Тэтгэврийн даатгал	14,160,443.00	19,577,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,665,934.00	2,185,818.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,272,267.00	1,708,335.00
210204	Ажилгүйдлийн даатгал	249,795.00	329,582.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,497,942.00	3,295,851.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,207,247.00	8,429,500.00
210301	Гэрэл, цахилгаан	995,691.00	1,503,097.00
210302	Түлш, халаалт	5,493,859.00	6,263,677.00
210303	Цэвэр, бохир ус	717,697.00	662,726.00

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	17,211,790.00	25,098,090.00
210401	Бичиг хэрэг	8,299,590.00	7,871,850.00
210402	Тээвэр, шатахуун	5,610,000.00	7,710,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	1,467,612.00
210404	Ном, хэвлэл	31,900.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,961,300.00	7,248,628.00
2105	Нормативт зардал	66,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	66,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,415,400.00	23,724,700.00
210604	Урсгал засвар	5,415,400.00	23,724,700.00
2107	Томилолт, зочны зардал	994,600.00	3,991,000.00
210702	Дотоод албан томилолт	994,600.00	3,991,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,552,920.00	10,142,618.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,934,400.00	9,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	194,200.00	194,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	118,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	8,220.00	8,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,152,837.44	31,840,437.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,060,000.00	3,340,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,238,450.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,854,387.44	27,950,237.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,823,386.00	10,879,352.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,472,000.00	999,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,692,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	999,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,351,386.00	9,879,652.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,351,386.00	9,879,652.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	88,706,218.65	33,308,660.82
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	540,666.07
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	540,666.07
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	88,706,218.65	32,767,994.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	-1,912,262.05	146,435,479.95
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	-1,912,262.05	146,435,479.95
3	Тайлант үеийн үр дүн	0	0	88,706,218.65	88,706,218.65
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	86,793,956.60	235,141,698.60
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	86,793,956.60	235,141,698.60
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	86,793,956.60	235,141,698.60
7	Тайлант үеийн үр дүн	0	0	32,767,994.75	32,767,994.75
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	119,561,951.35	267,909,693.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	309,153,600.00	390,981,479.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,175,000.00	20,475,079.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,175,000.00	20,475,079.00
120009	Бусад орлого	20,175,000.00	20,475,079.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	288,978,600.00	370,506,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	288,978,600.00	370,506,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	288,978,600.00	370,506,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	243,814,242.00	387,994,479.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,814,242.00	387,994,479.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,990,856.00	337,115,127.00

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,161,861.00	221,248,961.00
210101	Үндсэн цалин	91,739,295.00	142,273,318.00
210102	Нэмэгдэл	62,699,566.00	67,105,643.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,723,000.00	11,870,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,846,378.00	27,097,548.00
210201	Тэтгэврийн даатгал	14,023,520.00	19,577,961.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,665,933.00	2,185,819.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,272,267.00	1,708,335.06
210204	Ажилгүйдлийн даатгал	262,697.00	329,582.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,621,961.00	3,295,850.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,207,247.00	8,429,500.00
210301	Гэрэл, цахилгаан	995,691.00	1,503,097.00
210302	Түлш, халаалт	5,493,859.00	6,263,677.00
210303	Цэвэр, бохир ус	717,697.00	662,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,607,700.00	23,405,500.00
210401	Бичиг хэрэг	7,674,000.00	7,387,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,560,000.00	7,710,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	1,467,612.00
210404	Ном, хэвлэл	183,700.00	409,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,590,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,570,000.00	5,631,388.00
2105	Нормативт зардал	65,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,543,600.00	24,010,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	0
210604	Урсгал засвар	7,483,600.00	24,010,000.00
2107	Томилолт, зочны зардал	994,600.00	3,991,000.00
210702	Дотоод албан томилолт	994,600.00	3,991,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,168,520.00	10,142,618.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,550,000.00	9,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	194,200.00	194,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	118,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	8,220.00	8,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,395,950.00	18,790,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,395,950.00	14,790,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,823,386.00	50,879,352.00

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	40,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	40,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,472,000.00	999,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,692,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	999,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,351,386.00	9,879,652.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,351,386.00	9,879,652.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	65,339,358.00	2,987,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	45,339,358.00	22,987,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,339,358.00	22,987,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,339,358.00	22,987,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,339,358.00	22,987,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-45,339,358.00	-22,987,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,000,000.00	-20,000,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	20,000,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000,000.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,506,400.00	360,626,748.00	9,879,652.00	97.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,506,400.00	360,626,748.00	9,879,652.00	97.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,506,400.00	359,627,048.00	9,879,352.00	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,000,400.00	220,972,682.00	8,027,718.00	96.5
210101	Үндсэн цалин	144,767,700.00	141,997,039.00	2,770,661.00	98.1
210102	Нэмэгдэл	71,109,500.00	67,105,643.00	4,003,857.00	94.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,123,200.00	11,870,000.00	1,253,200.00	90.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,926,000.00	27,097,548.00	1,828,452.00	93.7

**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	21,096,400.00	19,577,961.68	1,518,438.32	92.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,957,400.00	2,185,819.08	-228,419.08	111.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,565,900.00	1,708,335.06	-142,435.06	109.1
210204	Ажилгүйдлийн даатгал	391,500.00	329,582.02	61,917.98	84.2
210205	Эрүүл мэндийн даатгал	3,914,800.00	3,295,850.16	618,949.84	84.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,429,500.00	8,429,500.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,440,000.00	1,503,097.00	-63,097.00	104.4
210302	Түлш, халаалт	5,789,500.00	6,263,677.00	-474,177.00	108.2
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	662,726.00	537,274.00	55.2
2104	Хангамж, бараа материалын зардал	23,206,700.00	23,206,700.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	7,387,500.00	7,387,500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,710,000.00	7,710,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,467,612.00	132,388.00	91.7
210404	Ном, хэвлэл	409,200.00	409,000.00	200.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,300,000.00	5,432,588.00	-132,588.00	102.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,010,000.00	46,997,000.00	13,000.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,987,000.00	13,000.00	99.9
210602	Тавилга	14,000,000.00	14,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	24,010,000.00	24,010,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	3,991,000.00	9,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,991,000.00	9,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,142,800.00	10,142,618.00	182.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,800,000.00	9,800,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	194,300.00	194,250.00	50.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,200.00	118,148.00	52.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	8,300.00	8,220.00	80.00	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,791,000.00	18,790,000.00	1,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,791,000.00	14,790,000.00	1,000.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	999,700.00	300.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0	0.00	#DIV/0!

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	0	0.00	#DIV/0!
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	999,700.00	300.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	999,700.00	300.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,506,400.00	360,626,748.00	9,879,652.00	97.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	370,506,400.00	360,626,748.00	9,879,652.00	97.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	370,506,400.00	360,626,748.00	9,879,652.00	97.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13		100
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	2	2		100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8		100
650012	Шүүгч, прокурор	3	3		100

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар *Ицаашид Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар гэх/*ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар нь “Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар нь 2021 онд баримтлах үйл ажиллагааны зорилт, чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,
- Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,
- Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,
- Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,
- Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын үйл ажиллагаанд МУЕПГ-ын Дотоод аюулгүй байдал, шалгалт, шалгалтын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, хууль хэрэгжүүлэн ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 362,175.9 мянган төгрөгийн 1.5 хувиар буюу 5,432.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,074.5 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.0 хувиар буюу 12,768.0 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн харилцах, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлогын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Банкинд байгаа нөөцийн харилцах	20,000.0	-	(20,000.0)
Урьдчилж төлсөн зардал	-	14,240.0	14,240.0
Бараа материал	9,279.8	11,312.5	2,032.7
Үндсэн хөрөнгө	225,861.9	242,357.2	16,495.3
Нийт хөрөнгө	255,141.7	267,909.7	12,768.0
Урьдчилж орсон орлого	20,000.0	-	(20,000.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	235,141.7	267,909.7	32,768.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	255,141.7	267,909.7	12,768.0

Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрсөн таслан шийтгэх арга хэмжээний 20,000.0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж, 2021 оны эхний үлдэгдлээр тайлагнасныг хэрэг таслан шийдвэрлэгдсэний дараа буцаан олгосны улмаас харилцах данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 14,240.0 мянган төгрөг болсон нь төлөвлөсөн сургалтыг тайлант онд багтаан зохион байгуулж амжилгүйгээр сургалтын төлбөрийг гэрээт харилцагчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,312.5 мянган төгрөг болж 2,032.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 50,186.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон дээд шатны захирагчаас үнэ төлбөргүйгээр 2,979.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаандаа 51,132.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 302,901.9 мянган төгрөг болж 41,742.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 22,987.0 мянган тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, МУЕПГ-аас 21,999.20 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ТӨБЗГ-ын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай 44 дүгээр тогтоолыг үндэслэн 3,244.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй автомашиныг данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 267,909.7 мянган төгрөг болж өмнөх оноос 32,768.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 430,271.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг урсгал зардлыг 171,616.0 мянган төгрөгөөр бууруулж, 258,655.5 мянган төгрөгөөр баталсан байна.

МУЕПГ-аас батлагдсан төсөвт 2021 оны 3,10 дугаар сард өөрчлөлт оруулж, 4 орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин, хөлс болон НДШ-ийн зардлыг 37,720.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 46,110.0 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 14,791.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 510.0 мянган төгрөгөөр зэрэг нийт зардлыг 111,850.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 370,506.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360,626.7 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 9,856.2 мянган төгрөгөөр, бусад зардлыг 23.5 мянган төгрөгөөр зэрэг нийт зардлыг 9,879.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 МУЕПГ-аас төсвийн жилийн эцэст буюу 2021 оны 10 дугаар сард хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 14,791.0 мянган төгрөгөөр, тавилга худалдан авах зардлыг 14,000.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 23,110.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, төсвийн зохицуулалт хийсэн байна.

Энэ нь төсвийг төсвийн жилийн хугацаанд багтаан зарцуулах цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэх, үүнээс шалтгаалан авлага үүсгэх эрсдэлийг үүсгэснээс төлөвлөсөн сургалтыг тайлант онд багтаан зохион байгуулж амжилгүйгээр 14,240.0 мянган төгрөгийг гэрээт харилцагчид шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнаж, авлага үүсгэсэн байна. Цаашид гэрээт ажлыг тухайн төсвийн жилд багтаан хэрэгжүүлэх боломжтой хугацаанд нь тооцож, төсөвт зохицуулалт хийж, санхүүжилтийг шийдвэрлэж байх нь зүйтэй юм.

3.7.2 МУЕП-ын 2021 оны А/176 дүгээр тушаалаар газрын нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу **478.6** мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан буюу тогтоосон хэмжээг хэтрүүлэн олгох шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх *"Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох"*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол *"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"*-ын 3 дугаар хавсралтын 2.2-т *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна."* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгээ үнэлүүлж, мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангаар "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйлгээ гэх үндэслэлээр төсвийн санхүүжилтийн 14 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **76,101.8** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14,649.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 61,452.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулга

- Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 409.0 мянган төгрөгийн номыг бараа материалын дансанд бүртгэж, залруулав.
- Гэрээт ажил буюу сургалт зохион байгуулагдаагүй байхад хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын 14,240.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, зарлагаар тайлагнасныг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж, залруулав.

4.2 Зөвлөмж

Анхан шатны баримт болон төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 59,634.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд явсан км-ыг бодитоор бүртгээгүй, авто машины 100 км-т зарцуулах шатахууны нормыг ажиглалт хийж, баталгаажуулаагүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 1,818.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 3 дугаар хавсралт “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тогтоох аргачлал, зөвлөмж”-ийг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Авто машины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалын дагуу тогтоосны үндсэн дээр шатахуун олгож байх, жолоочийн тооцооны хуудсанд явсан км-ыг бодитоор бүртгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар	4	76,101.8	2	14,649.0					2	61,452.8